

**Хүний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг
боловсронгуй болгох шаардлага
(Эрүүл мэндийн мэдээллийн хүрээнд)**

**Improving the Legal Framework for Personal Data
Protection: Issues in The Regulation of Health Data**

Баяраагийн Баялагмаа

<https://orcid.org/0000-0002-6882-5733>

Хууль зүйн ухааны магистр (LL.M.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Хувийн эрх зүйн тэнхимийн багш

Улаанбаатар хот, Монгол Улс

bayalagmaa@num.edu.mn

© B.Bayalagmaa, 2026



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр цахим орчинд хувь хүний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүний хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын ач холбогдол нэмэгдэж байна. Монгол Улсад 2021 онд Цахим хөгжлийн багц хуулиуд батлагдаж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хүний хувийн болон эмзэг мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан. Гэвч эдгээр зохицуулалтууд нь эрүүл мэндийн салбарт хиймэл оюун болон шинэ төрлийн бусад технологид суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн технологи, мэдээллийн системийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр үйлчлүүлэгч, өвчтөн, хэрэглэгчдийн эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах, бусдад дамжуулахтай холбоотой харилцааг зохицуулахад хангалтгүй байна. Цаашлаад зохицуулалтын хэрэгжилтийн тодорхой бус байдал нь эрүүл мэндийн мэдээллийг зүй бусаар ашиглаж буй эсэх, эрүүл мэндийн байгууллага хооронд мэдээлэл дамжуулахад хяналт тавьж буй эсэх, эрүүл мэндийн мэдээллийн засаглалд суурилж эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа сайжирч буй эсэх асуудлууд хөндөгдөж байна. Тиймээс энэ өгүүллийн хүрээнд эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахтай холбоотой зохицуулалтын тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийх замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлж, холбогдох дүгнэлтийг гаргахыг зорилоо.

[Түлхүүр үг]

Эрүүл мэндийн мэдээлэл, хувийн халдашгүй байдал, кибер аюулгүй байдал, хандах эрх, хувийн мэдээллийн хамгаалалт.

I. Оршил

Мэдээлэл технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ өсөн нэмэгдэж буй өнөө цагт хүний “хувийн мэдээлэл”-ийг хамгаалах зохицуулалтыг бий болгож, түүнийг хэрэгжүүлэх нь цахим орчимд иргэний хувийн халдашгүй байдлыг хамгаалах үндсэн нөхцөл юм. Манай улс нь 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг баталж, тус хуулиар хувийн нууцад захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууцыг төрөлжүүлэн тодорхойлж, хувь хүний нууцыг хуулиар хамгаалж ирсэн хэдий ч цахим орчинд хувь хүний нууцаас гадна хүний хувийн мэдээллийг ашиглах замаар хувь хүнд хохирол учруулах, цаашлаад их хэмжээний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр цуглуулах, арилжаалах, хувь хүний шийдвэр гаргалтад нөлөөлөх эрсдэлүүд бий болж байна.

Цахим орчинд хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 онд Цахим хөгжлийн багц хуулиуд батлагдаж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар “хүний хувийн мэдээлэл”, “эмзэг мэдээлэл”-ийг тухайлан тодорхойлж, хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч эрүүл мэндийн салбарт шинэ төрлийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдацтай нэвтэрч, хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр өвчтөний, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах асуудлууд үүссээр байна. Тухайлбал, бусад улс орны хөгжүүлсэн хиймэл оюунд суурилсан оношилгоо төхөөрөмжийн хэрэглээ нэгэнт бий болсон хэдий ч өвчтөний хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах, бусад улсад дамжуулж буй эсэх, дамжуулах журмын талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Нөгөөтээгүүр, Кибер аюулгүй байдлын тухай хуулиар онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллагад тавигдах шаардлагыг тодорхойлж, нийтлэг байдлаар эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулсан хэдий ч, 2024 оны 11 дүгээр сард хувийн эмнэлгийн мэдээллийн систем кибер халдлагад өртөж, өвчтөн, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн мэдээлэл задрах эрсдэл үүссэн нь нийтэд илэрхий болсон үйл явдал юм.

Иймд эрүүл мэндийн мэдээлэл нь хувь хүний нууц төдийгүй, эмзэг мэдээлэл тул салбарын онцлогт нийцүүлэн эдгээр мэдээллийг хамгаалах, ашиглах, дамжуулах зохицуулалт тодорхой, нийтэд ойлгомжтой байх нь зайлшгүй билээ. Тус өгүүллийн хүрээнд эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах зорилгоор эрүүл мэндийн мэдээллийн засаглалыг бэхжүүлэх, эрүүл мэндийн мэдээллийг хамгаалахтай холбоотой тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийх замаар эрүүл мэндийн мэдээллийг боловсруулах, ашиглах шаардлагыг

боловсронгуй болгох үндэслэлүүдийг тодорхойлж, холбогдох дүгнэлтийг гаргахыг зорилоо.

II. Эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин

Монгол Улсын эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин нь мэдээлэл хамгаалах, дижитал шилжилтийн бодлогын баримт бичигт тусгагдсан үзэл санаа, стратеги болон салбарын хууль тогтоомжоор тодорхойлсон зохицуулалтаас бүрддэг. Дижитал шилжилтийн бодлогын суурь баримт бичгүүдийг дараах байдлаар он цагийн дараалалд оруулж, системчилж болохоор байна. Үүнд: (1) Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 216 дугаартай тогтоолоор баталсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, (2) Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор баталсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөр, (3) Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр, (4) Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, (5) Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны Сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дугаартай тушаалаар баталсан “Цахим үндэстэн” (2022-2027) баримтлах чиглэл, (6) Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө” зэрэг хамаарна.

Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 216 дугаартай тогтоолоор баталсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр¹ нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012 он) хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон. Тус хөтөлбөрийн хэрэгжүүлэх стратеги хэсэгт “Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх” стратегийг тухайлан тодорхойлсон байдаг. Энэхүү стратегийн хүрээнд 2007-2010 оны хооронд (1) өвчний цахим түүхийг бий болгох, эмнэлэг, өвчтөн, эрүүл мэндийн даатгалыг хамарсан нэгдсэн сүлжээ, өгөгдлийн сан, архив байгуулан цаасгүй эмнэлэг технологид шилжих, цаасан дээр бичиж тэмдэглэх, лабораторийн шинжилгээ, оношилгооны үр дүн, эмийн сангаас олгосон эм, хийсэн эмчилгээ, мэс ажилбар, хоол, төлбөрийн баримт зэрэг бүх мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах (e-medical record), (2) эрүүл мэндийн салбарын хэмжээнд мэдээлэл харилцаа холбооны технологийн удирдлага, бодлого, зохицуулалтын

¹ Монгол Улсын Засгийн газар, 2005, дугаар 216, Хөтөлбөр батлах тухай /Цахим Монгол/ тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=5196>.

тогтолцоог боловсронгуй болгох, үүнтэй холбогдсон стандартуудыг боловсруулах, (3) эрүүл мэндийн нэгдсэн сүлжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахаар тодорхойлсон.

Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор баталсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн² үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 дугаар хэсэгт төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох зорилтын хүрээнд 2012-2016 оны хооронд эрүүл мэндийн салбарт дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: (1) эрүүл мэндийн алсын зайн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, (2) эмнэлгүүдийг өндөр хурдны сүлжээнд холбох, мэдээлэл (өвчний түүх) солилцох боломжоор хангах, (3) өвчлөлийн тандалт, статистик мэдээллийн сан, мэдээллийн систем бий болгох, (4) иргэний эрүүл мэндийн даатгалын хяналтын системийг хөгжүүлэх, (5) хүнсний болон эмийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтын систем нэвтрүүлэх арга хэмжээ тус тус багтаж байна. Эдгээр арга хэмжээнүүдийн (1), (2)-т заасан арга хэмжээ нь өмнө дурдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөртэй уялдаатай “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2012-2016 онд уг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ нь 55% байгаа талаар судалгааны дүгнэлт гарсан байна.³

Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийн⁴ 4.1.4-т зааснаар төрийн цахим мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн байдал, нэгдмэл аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд эрүүл мэндийн салбарт хамаарах тусгайлсан зохицуулалтыг тусгаагүй байна. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор тус хөтөлбөрийг

² Монгол Улсын Засгийн газар, 2012, дугаар 101, “Цахим засаг” үндэсний хөтөлбөр батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/9465/2/206019>.

³ Удирдлагын академи, “Цахим засаглалын хөгжлийн бодлого, зохицуулалтын шинжилгээ” судалгааны тайлан, 2020. 65 дахь тал.

⁴ Монгол Улсын Засгийн газар, 2019, дугаар 73, Үндэсний хөтөлбөр батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/14177/2/209503>. (Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.)

хүчингүй болгожээ.⁵

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын⁶ баримт бичиг нь (1) АЛСЫН ХАРАА -2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, (2) АЛСЫН ХАРАА – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, (3) АЛСЫН ХАРАА-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин гэсэн 3 баримт бичгээс бүрдэнэ. АЛСЫН ХАРАА – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.2-т заасны дагуу эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэний төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ. Мөн энэ бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.28-д зааснаар эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжих зохицуулалттай.

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны Сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дугаартай тушаалаар баталсан “Цахим үндэстэн” (2022-2027) баримтлах чиглэлийн⁷ 6.1-т заасны дагуу үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж, дижитал эдийн засгийг хөгжүүлэх бөгөөд 6.1.11-т зааснаар эрүүл мэндийн салбарт алсын зайн дүрст эмнэлзүйн оношилгоог хөгжүүлж, эрүүл мэндийн цахим бүртгэл, өвчтөний түүх, эмчийн цахим жор, эм эмнэлгийн хэрэгслийн өгөгдлийн санг сайжруулж, эрүүл мэндийн байгууллагуудын хооронд өгөгдөл солилцох платформыг нэвтрүүлж, “нэг өвчтөн нэг эрүүл мэндийн түүх” гэсэн зарчмаар цахим эрүүл мэндийн системийг бий болгох чиглэлийг тодорхойлсон нь эрүүл мэндийн мэдээллийг боловсруулах, ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг үүсгэж байна.

⁵ Мөн тэнд.

⁶ Монгол Улсын Их Хурал, 2020, дугаар 52, “Алсын хараа-2050» Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/15406>.

⁷ Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, 2022, дугаар А/24, Баримтлах чиглэл батлах тухай тушаал, https://mddic.gov.mn/wp-content/uploads/2022/07/%D0%9024-20220518-%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D1%82%D1%8D%D0%BD-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC-%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%87%D0%B8%D0%B3%D0%BB%D1%8D%D0%BB-%D0%B1%D0%B0%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9_1658190818-1-1.pdf.

Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө” нь 2025-2028 оны хооронд дараах зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон. (1) Эрүүл мэндийн цахим шилжилтийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, (2) цахим эрүүл мэндийн дэд бүтцийг бэхжүүлэх, (3) өгөгдлийн ангилал кодчиллыг боловсронгуй болгох, эрүүл мэндийн Их өгөгдлийг бий болгох, (4) Иргэн төвтэй, цахим эрүүл мэндийн үйлчилгээ нэвтрүүлэх, (5) мэдээллийн аюулгүй байдлыг хангах, (6) алсын зайн технологийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх, (7) Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хяналтын тогтолцоо, (8) хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, (9) цахим эрүүл мэндийг дэмжих, хамтын ажиллагааг бэхжүүлэх, (10) дижитал шилжилтийн хэрэгжилтийг үнэлэх, хянах тогтолцоог бий болгох үйл ажиллагаануудыг зохион байгуулахаар байна.⁸

Дээрх бодлогыг баримт бичигт дурдсан эрүүл мэндийн мэдээллийг хамгаалахтай холбоотой авах арга хэмжээний зохицуулалт, хэрэгжилтийг харьцуулан авч үзвэл, Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа, төлөвлөгөөнд тусгагдсанаар эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийг хүлээн зөвшөөрч, дэмжихэд чиглэж байгаа хэдий ч үйлчлүүлэгч, өвчтөний эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах, халдашгүй байдлыг хангах хүрээнд хийвэл зохих үйл ажиллагаанууд тусгагдаагүй, ерөнхий хувийн мэдээллийг хамгаалахад чиглэгдсэн. Үүнээс гадна, эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, боловсруулахад хувийн халдашгүй байдлыг зайлшгүй хангах үндсэн суурь нөхцөлийг хангасан арга хэмжээг хэрэгжүүлсэн, түүнийг үнэлж дүгнэсэн тайлан, эх сурвалжууд гаргаагүй эсхүл олон нийтэд нээлттэй бус байгаа нь эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах асуудалд ач холбогдол өгч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа байгаа эсэх нь тодорхойгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Эрүүл мэндийн салбар дах эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах тогтолцоо нь зөвхөн цаасан суурьт баримт бичигт бус аливаа шинэ төрлийн технологид суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хэрэглэж буй хэрэглэгч, өвчтөний мэдээллийг

⁸ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай тушаал, 2025, дугаар А/201, А/81, <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2025/06/%D0%AD%D0%9C-%D0%B4%D0%B8%D0%B6%D0%B8%D1%82%D0%B0%D0%BB-%D1%88%D0%B8%D0%BB%D0%B6%D0%B8%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D3%A9-%D0%BB%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%B3%D3%A9%D3%A9.pdf>.

хамгаалах нөхцөлийг хуулиар зохицуулах нь зүйтэй. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т зааснаар даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан цахим картыг хүн бүрд үүсгэх бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10-т авсан эрүүл мэндийн үйлчилгээний мэдээлэлд даатгуулагч цахим байдлаар хяналт тавих эрхийг тусгасан. Эдгээр мэдээллийг хадгалж буй эрүүл мэндийн мэдээллийг хадгалж буй эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сантай холбоотой харилцааг Засгийн газрын 2016 оны 279 дүгээр тогтоолоор баталсан Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим сангийн дүрмээр зохицуулдаг. Тус дүрмийн 6.1 дэх хэсэгт зааснаар мэдээллийн санг ашиглах явцад мэдээлэл алдагдах, устгах зэрэг аюултай нөхцөл байдал үүссэн нөхцөлд гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан боловч өвчтөн, үйлчлүүлэгчид учирсан хохирлыг мэдээлэл хариуцагч хариуцан барагдуулах зарчмыг тусгаагүй орхигдуулжээ.

Нөгөөтээгүүр, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар⁹ эрүүл мэндийн мэдээллийг “эмзэг мэдээлэл” гэж тодорхойлсонтой холбоотойгоор Цахим хөгжил, харилцааны холбооны яамны Сайдын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/90 дугаар тушаалаар “Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам”-ыг¹⁰ баталсан. Гэвч тус журмын эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, боловсруулж буй эрүүл мэндийн байгууллагууд нэг мөр дагаж мөрдөхгүй байгаагийн зэрэгцээ эрүүл мэндийн оношилгоо, бүртгэлийн тоног, төхөөрөмж, системүүд нь тус журамд заасан технологийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх нь тодорхойгүй, тодорхой шаардлагыг хангасан технологийн жагсаалт өнөөдрийг хүртэл гараагүй байна.

Эрүүл мэндийн байгууллагын ашиглаж буй мэдээллийн систем, сан, программ хангамжийн аюулгүй байдлын шаардлагыг Кибер аюулгүй байдлын тухай хууль¹¹, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор баталсан “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”¹², Цахим хөгжил, инновац, харилцаа

⁹ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021), *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №07*.

¹⁰ Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, 2023, А/90 дүгээр тушаалын хавсралт, Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам, <http://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452348261>.

¹¹ Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021), *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022, №08*.

¹² Монгол Улсын Засгийн газар, 2023, 224 дүгээр тогтоолын хавсралт, Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, <https://legalinfo.mn/mn/>

холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/30, А/148 дугаартай тушаалаар баталсан “Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал”¹³, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 207 дугаар тогтоолоор баталсан “Онц чухал мэдээллийн дэд бүтэц байгууллагын жагсаалт”¹⁴, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 493 дугаар тогтоолоор баталсан “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”¹⁵, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын хамтарсан 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/119, А/137, А/616 дугаартай тушаалаар баталсан “Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”¹⁶-өөр тус тус зохицуулж байна. Дээрх зохицуулалтуудыг эрүүл мэндийн байгууллагад дагаж мөрдөж буй эсэхэд үнэлгээ хийж, нэг мөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах нь зайлшгүй буюу хэдийгээр нийтлэг дүрэм, журам батлагдсан боловч эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлснээр эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд үзүүлж буй эерэг, эсхүл сөрөг үр нөлөөг тодорхойлох нөхцөл бүрдэх юм.

Эрүүл мэндийн салбар дах дижитал шилжилт, цахим хөгжлийн дээрх эрх зүйн зохицуулалтуудаар хүний хувийн мэдээлэл, кибер аюулгүй байдалд хамаарах харилцааг ерөнхийлөн зохицуулсан байх бөгөөд эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах, эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийг мэдээллийг ашиглах, дамжуулахтай

detail?lawId=16759862495731.

¹³ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга, 2024, дугаар А/30, А/148, Журам батлах тухай тушаал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141973551921>.

¹⁴ Монгол Улсын Засгийн газар, 2022, дугаар 207, Жагсаалт батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530379603681>.

¹⁵ Монгол Улсын Засгийн газар, 2022, дугаар 493, Үндэсний стратеги батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532522757001>.

¹⁶ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, 2023, дугаар А/119, А/137, А/616, Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай тушаал, <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2024/07/%D0%90119-%D0%90137-%D0%90616-20231117-%D0%9A%D0%90%D0%91-%D1%8B%D0%BD-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%81%D1%82%D1%80%D0%B0%D1%82%D0%B5%D0%B3%D0%B8%D0%B9%D0%B3-%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3%D0%B6%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D1%85-%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0-%D1%85%D1%8D%D0%BC%D0%B6%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%82%D3%A9%D0%BB%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%B3%D3%A9%D3%A9%D0%B3-%D0%B1%D0%B0%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9.pdf>.

холбоотой тусгайлсан зохицуулалт нь эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжид дараах байдлаар тусгагджээ. Үүнд:

Эрүүл мэндийн тухай хуулийн¹⁷ 8.4-т зааснаар эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газар батлахаар зохицуулсан. Түүнчлэн хуулийн 8.10-д зааснаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран батлахаар зохицуулалттай.

Дээрх чиг үүргийн хүрээнд захиргааны эрх бүхий байгууллагуудаас (1) Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/611 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу эрүүл мэндийн мэдээллийн бүртгэлийг хийж, цахим мэдээний сан бүрдүүлнэ.¹⁸ (2) Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам”¹⁹, (3) Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/130, А/58 дугаартай тушаалаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага”, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам”²⁰ тус тус баталсан байх бөгөөд хэрэгжилтийг нэг мөр хангах шаардлагыг үүсгэж байна.

¹⁷ Эрүүл мэндийн тухай хууль (2011), *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №21*.

¹⁸ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, 2019, дугаар А/611, Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай тушаал, https://hdc.gov.mn/media/files/ambulatori%202020.11.11%20a_SaD9HaA.pdf.

¹⁹ Монгол Улсын Засгийн газрын 100 дугаар тогтоолын хавсралт, 2024, Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089589982521&showType=1/>.

²⁰ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцааны холбооны сайд, 2025, Дугаар А/130, А/58, Журам шаардлага шинэчлэн батлах тухай тушаал, <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2025/06/%D0%AD%D0%9C-%D1%82%D1%83%D1%81%D0%BB%D0%BC%D0%B6-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B4-%D0%BF%D1%80%D0%BE%D0%B3%D1%80%D0%B0%D0%BC%D0%BC-%D1%85%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B0%D0%BC%D0%B6%D0%B8%D0%B9%D0%BD-%D2%AF%D0%BD%D1%8D%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D-%D1%85%D0%B8%D0%B9%D1%85.pdf>.

Ш. Эрүүл мэндийн мэдээллийн засаглалын хүрээнд хувийн халдашгүй байдлыг хангахтай холбоотой асуудлууд

Эрүүл мэндийн мэдээллийн засаглалыг бэхжүүлэх хүрээнд (1) Хувь хүнийг хамгаалах, (2) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжих, (3) Тэгш хүртээмжтэй байдлыг бий болгох үндсэн гурван зорилтуудын биелэлтийг хангах шаардлага үүсдэг.²¹ Хувь хүнийг хамгаалах зорилтын хүрээнд хувь хүн болон нийгмийн бүлгийн эрүүл мэндийн хамгаалах зарчим, эрүүл мэндийн мэдээллийг боловсруулах хэвийн, найдвартай мэдээллийн системтэй байх зарчим, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчмыг удиртгал болгон хэрэгжүүлнэ.²²

Ш.1. Хувь хүн болон нийгмийн бүлгийн эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах зарчим

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дах хэсэгт хүн бүр халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, иргэн, хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалдаг. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дах хэсэгт мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлахаар хуульчилсан нь хувь хүн болон нийгмийн бүлгийн эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах зарчмыг тусгасан гэж үзэж болох юм. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт мэдээлэл хариуцагч хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс зайлшгүй зөвшөөрөл авах бөгөөд мөн хуулийн 8.1.2 дах заалтад зааснаар мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзэнд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго, ойлгомжтой тодорхой мэдээлсэн байх хуулийн шаардлагатай.

Түүнчлэн, Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмын 2.4-т заасны дагуу Мэдээлэл хариуцагч нь хүний хувийн мэдээллийг анх цуглуулахад болон мэдээлэл хариуцагч мэдээлэл дамжуулахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах журамтай. Харин Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлд мэдээллийн эзний зөвшөөрлөөр, эсхүл тухайн хүн болон бусдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтан хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх, эсхүл иргэн хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагад хуульд заасан дагуу тайлбар, мэдүүлэг, нотлох баримтыг өгөхөөс бусад тохиолдолд хүний эмзэг мэдээллийг

²¹ Health Data Governance, Health Data Governance Principles, <https://healthdatagovernance.org/>.

²² Health Data Governance, Health Data Governance Principles, <https://healthdatagovernance.org/principles/>.

цуглуулж, боловсруулж, ашиглахыг хориглодог. Энэ зохицуулалтын агуулгаар аливаа хүний эрүүл мэндийн мэдээллийг зүй бусаар ашиглахыг хуулиар хориглосон гэж дүгнэж болно.

Гэхдээ ямар тохиолдлыг зүй бусаар ашигласанд тооцох вэ? гэх асуулт гарч ирсээр байна. Иймд зохисгүй байдлаар ашиглаж болох үйлдлүүдийг мэдээлэл цуглуулах зорилготой уялдуулан тодорхойлох нь зүйтэй. Нөгөөтээгүүр, нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан эрүүл мэндийн мэдээллийг хүлээн авах, ашиглах, хамгаалах, урьдчилсан дүгнэлт, таамаг, хэвшмэл ойлголтод тулгуурлан эрүүл мэндийн мэдээллийг цуглуулснаас үүдэж мэдээллийг үнэн зөв байдлын алдаг (*confirmation bias*) үүсэж, улмаар эрүүл мэндийн мэдээллийн чанар алдагдах, хувь хүний халдашгүй байх эрх зөрчигдөх, мэдээлэл хүртээмжгүй байх сөрөг үр дагавар үүсэж болзошгүй байна. Тиймээс нийгмийн бүлэгт (трансгендер, бие үнэлэгч, хоригдол, архидан мансуурах донтой иргэд)²³ үндэслэн (*confirmation bias*)-аас урьдчилан сэргийлэх тухайлсан зохицуулалтыг боловсруулах шаардлагыг үүсгэж байна.

Эрүүл мэндийн мэдээллийн засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагаа, авч буй арга хэмжээ нь ялгаварлан гадуурхалтаас ангид байснаар хувийн халдашгүй байдлыг хамгаалах, тэгш байдлыг хангах нөхцөл бүрдэнэ. Одоогоор манай улсын аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагыг мэдээллийн систем хөгжүүлэх шатанд тавихгүй байгааг өөрчлөх нь зайлшгүй юм.

Эрүүл мэндийн мэдээллийн засаглалын хүрээнд боловсруулсан Эрүүл мэндийн мэдээллийн засаглалын загвар хуульд²⁴ “community data” буюу “нийгмийн бүлгийн эрүүл мэндийн мэдээлэл” мэдээллийг тусгажээ. Өөрөөр хэлбэл, тухайлсан өвчтөний бүлэг, тодорхой өвчинд өртөмтгий хэсэг бүлэг хүмүүсийн хувьд хамтын эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах шаардлага үүсэх тул тухайн бүлгийн эрхийг хамгаалах хүрээнд хамтын зөвшөөрлийн зайлшгүй авах шаардлагыг тодорхойлсон байна. Монгол Улсын хувьд хамтын мэдээлэл, зөвшөөрлийн зохицуулалтыг боловсруулах нь бүлэгт хамаарах хүмүүсийн халдашгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна.²⁵

²³ Health Data Governance, Health Data Governance Principles, <https://healthdatagovernance.org/wp-content/uploads/2024/11/EN-Health-Data-Governance-Principles-1.pdf>.

²⁴ Health Data Governance, Model Law on Health Data Governance, <https://healthdatagovernance.org/model-law/>, (2024).

²⁵ Health Data Governance, *supra* note 23.

III.2. Эрүүл мэндийн мэдээллийг боловсруулах хэвийн, найдвартай мэдээллийн системтэй байх зарчим

Европын Хүний хувийн мэдээлэл хамгаалах ерөнхий журмын дагуу мэдээлэл хариуцагчаас клиникийн туршилт, эсхүл гар утасны аппликейшнд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ (mobile health) зэрэг инновацыг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах үйл явцууд нь хувь хүний мэдээллийг хамгаалах, мэдээллийг найдвартай хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах тухайлсан хамгаалалтын арга хэмжээг хангах шаардлагыг тодорхойлдог.²⁶ Манай улсын Кибер аюулгүй байдлын тухай хуульд үндэслэн батлагдсан Онц чухал мэдээллийн дэд бүтцийн жагсаалтад зааснаар хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага, хүн, малын гоц халдварт өвчин судлах лаборатори, эм, химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэгч байгууллага нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар стандартыг нэвтрүүлэх үүрэг хүлээдэг.

Нөгөөтээгүүр, эрүүл мэндийн мэдээллийн чанар, хүртээмжийг хангах хүрээнд эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, боловсруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.10-т заасан нэгдсэн ангилал, код, тайлбар болон олон улсын стандарт, ICD, FHIR/HL7, SNOMED CT, LOINC-ын дагаж мөрдөхөөр зохицуулсан. Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмын дагуу Эрүүл мэндийн мэдээллийн төв нь мэдээлэл солилцооны системээр солилцох мэдээллийн агуулга, оролт, гаралтын нөхцөл, хувьсагчийг тогтоож, нийтэд ил тод, нээлттэй байршуулах журамтай. Эдгээр хууль тогтоомжоор мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах зохицуулалтыг тусгасан боловч эрүүл мэндийн салбарын онцлогоос зөвшөөрөл авахгүй байх тохиолдол, түүний хязгаарыг бүрэн зохицуулаагүй, мөн хамтын зөвшөөрөл, эрүүл мэндийн өгөгдлийн удирдлагыг нотолгоонд тулгуурлан бэхжүүлэх талаар зохицуулалт байхгүй байна.

III.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчим

Кибер аюулгүй байдлын нийтлэг журмаар мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдлыг хангах, кибер халдлага, кибер аюулгүй байдлын зөрчлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагаанд дагаж мөрдөх нийтлэг харилцааг зохицуулж байна.

Онц чухал дэд бүтцийн байгууллагын хувьд, аюулгүй байдлын заналхийлэлтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор аюулгүй

²⁶ The General Data Protection Regulation (GDPR), Health data, https://www.edps.europa.eu/data-protection/our-work/subjects/health_en.

байдлын эрсдэлийн үнэлгээг жил тутамд хийлгэх, мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутамд хийлгэх үүрэгтэй боловч нийтлэг байдлаар, тус арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагууд тогтмол хэрэгжүүлдэггүй, хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсдэг болохыг эрүүл мэнд, мэдээлэл технологийн салбарын албан хаагчдыг оролцуулсан 2025 онд зохион байгуулагдсан Эрүүл мэндийн өгөгдлийн засаглалын үндэсний хэлэлцүүлэгт танилцуулсан. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиас гадна, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах харилцааг Кибер аюулгүй байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын нийтлэг журмаар тухайлан зохицуулж байгаа хэдий ч кибер халдлага, зөрчилтэй холбоотой асуудлыг ил тод байлгах, мөн холбогдсон мэдээллийн системийг харгалзан үзэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Хэдийгээр Кибер аюулгүй байдлын тухай хуулиар кибер халдлага зөрчлийг мэдэгдэх хүртэл зохицуулсан боловч кибер халдлага, зөрчлийн нөхцөл байдал, үйлдсэн арга, алдагдсан мэдээлэл зэрэг мэдээллүүд ил тод байхгүй байгаа нь салбарын бусад байгууллагууд тухайн кейсээс суралцах, чадавхжих, үйл ажиллагааг сайжруулах боломжгүйд хүргэж байна.

IV. Дүгнэлт

Эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага нь эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин тодорхой бус, хэрэгжилт хангалтгүй байгаа зэрэг эрх зүйн тулгамдсан асуудлуудаар тодорхойлогдож байна. Түүнчлэн эрүүл мэндийн мэдээллийг хууль бусаар болон зохисгүй байдлаар ашиглах тохиолдлыг тодорхойлох замаар хувь хүний халдашгүй байдал төдийгүй нийгмийн тодорхой бүлгийн хувь хүмүүс, өвчтөний эрх ашгийг хамгаалах эрх зүйн баталгааг бэхжүүлэх нь зүйтэй. Үүнээс гадна, нийгмийн эмзэг, гадуурхагдаж болзошгүй бүлгийн эрүүл мэндийн мэдээллийг цахим орчинд цуглуулах, боловсруулах, хамгаалахтай холбоотой тусгай зохицуулалтыг бий болгох шаардлага байгаагийн зэрэгцээ эрүүл мэндийн мэдээллийн систем, программ хангамжийн хөгжүүлэлтийн бүх үе шатанд урьд нь бий болсон, эсхүл хэвшмэл ойлголтод тулгуурласан байдлаар мэдээллийн зөрүүтэй үр дүнг үүсгэхээс (*confirmation bias*) урьдчилан сэргийлэх хууль зүйн суурь нөхцөл тавигдаж буйг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай юм.

Цаашид хувь хүний эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд кибер аюул занал, зөрчлийн мэдээллийг талаар ил тод мэдээлэх, түүнээс урьдчилан сэргийлэх

арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн мэдээллийг боловсруулж буй системүүдийн үр нөлөө, уялдаа холбоонд тогтмол үнэлгээ хийж, сайжруулах нь эрүүл мэндийн дэмжих, хамгаалах үйл ажиллагааг сайжруулахад чухал ач холбогдолтой.

[Ном зүй]

Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022, №08, 2021 он.

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/15406>, 2020 он.

Монгол Улсын Засгийн газрын 100 дугаар тогтоолын хавсралт, Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089589982521&showType=1/>, 2024 он.

Монгол Улсын Засгийн газрын 101 дүгээр тогтоол, “Цахим засаг” үндэсний хөтөлбөр батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/9465/2/206019>, 2012 он.

Монгол Улсын Засгийн газрын 207 дугаар тогтоол, Жагсаалт батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530379603681>, 2022 он.

Монгол Улсын Засгийн газрын 216 дугаар тогтоол, Хөтөлбөр батлах тухай /Цахим Монгол/, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=5196>, 2005 он.

Монгол Улсын Засгийн газрын 224 дүгээр тогтоолын хавсралт, Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759862495731>, 2023 он.

Монгол Улсын Засгийн газрын 493 дугаар тогтоол, Үндэсний стратеги батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532522757001>, 2022 он.

Монгол Улсын Засгийн газрын 73 дугаар тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/14177/2/209503>, 2019 он. (Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.)

Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцааны холбооны сайдын А/130, А/58 дугаар тушаал, Журам шаардлага шинэчлэн батлах тухай, <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2025/06/%D0%AD%D0%9C-%D1%82%D1%83%D1%81%D0%BB%D0%B0%D0%BC%D0%B6-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B4-%D0%BF%D1%80%D0%BE%D0%B3%D1%80%D0%B0%D0%BC%D0%BC-%D1%85%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B0%D0%BC%D0%B6%D0%B8%D0%B9%D0%BD-%D2%AF%D0%BD%D1%8D%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D-%D1%85%D0%B8%D0%B9%D1%85.pdf>, 2025 он.

Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан А/201, А/81 дүгээр тушаал,

Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай, <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2025/06/%D0%AD%D0%9C-%D0%B4%D0%B8%D0%B6%D0%B8%D1%82%D0%B0%D0%BB-%D1%88%D0%B8%D0%BB%D0%B6%D0%B8%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D3%A9%D0%BB%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%B3%D3%A9%D3%A9.pdf>, 2025 он.

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын А/611 дүгээр тушаал, Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай, https://hdc.gov.mn/media/files/ambulatori%202020.11.11%20a_SAd9HaA.pdf, 2019 он.

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/24 дүгээр тушаал, Баримтлах чиглэл батлах тухай, https://mddic.gov.mn/wp-content/uploads/2022/07/%D0%9024-20220518-%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D1%82%D1%8D%D0%BD-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC-%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%87%D0%B8%D0%B3%D0%BB%D1%8D%D0%BB-%D0%B1%D0%B0%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9_1658190818-1-1.pdf, 2022 он.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга, дугаар А/30, А/148, Журам батлах тухай тушаал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141973551921>, 2024 он.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын хамтарсан А/119, А/137, А/616 дугаар тушаал, Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай, <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2024/07/%D0%90119-%D0%90137-%D0%90616-20231117-%D0%9A%D0%90%D0%91-%D1%8B%D0%BD-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%81%D1%82%D1%80%D0%B0%D1%82%D0%B5%D0%B3%D0%B8%D0%B9%D0%B3-%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3%D0%B6%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D1%85-%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0-%D1%85%D1%8D%D0%BC%D0%B6%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%82%D3%A9%D0%BB%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%B3%D3%A9%D3%A9%D0%B3-%D0%B1%D0%B0%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9.pdf>, 2023 он.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/90 дүгээр тушаалын хавсралт, Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам, <http://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452348261>, 2023 он.

Удирдлагын академи, “Цахим засаглалын хөгжлийн бодлого, зохицуулалтын шинжилгээ” судалгааны тайлан, Улаанбаатар: 2020 он.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №07, 2021 он.

Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №21, 2011 он.

General Data Protection Act (2018).

Health Data Governance Principles, (2022).

Health Data Governance, Model Law on Health Data Governance, <https://healthdatagovernance.org/model-law/>, (2024).

[Abstract]

Improving the Legal Framework for Personal Data Protection: Issues in The Regulation of Health Data

Bayalagmaa Bayaraa

Master of Laws (LL.M.).

*Lecturer at the Private Law Department,
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

As the use of products and services based on information and communication technologies continues to grow, the importance of legal regulations for the protection of personal data has increased. In Mongolia, the legal framework for protecting personal and sensitive data was established with the adoption of the Package Law on Digital Development and the Law on Personal Data Protection in 2021. However, with the growing use of artificial intelligence-based technologies and information systems in the healthcare sector, the regulation concerning the protection and transfer of patients' and clients' health data remains unclear. Within this context, this article analyzes key regulatory challenges related to the collection, processing, use, and protection of health data and identifies the need to improve the relevant legislation, presenting corresponding conclusions.

[Keywords]

Health data, Privacy, Cybersecurity, Access Rights, Personal Data Protection.